



**ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2025 оны 01 сарын 04 өдөр

Дугаар A/05

Хэрлэн сум

**Ардын их хурлын депутатуудад
хүндэтгэл үзүүлэх тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2, 14.2.3 дахь заалт, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалаар батлагдсан "Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам"-ын 2 дугаар зүйлийн 2.1.5 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Монгол Улсын Ардчилсан шинэ үндсэн хууль батлагдсаны 33 жилийн ойг тохиолдуулан Хэнтий аймгаас сонгогдсон ардын их хурлын депутатуудад, хүндэтгэл үзүүлж, 3,300,000 (гурван сая гурван зуун мянга) төгрөгийн хөрөнгө зарцуулсугай.

2. Хүндэтгэл үзүүлэх ардын их хурлын депутатуудын нэрсийг хавсралтаар баталсугай.

3. Дээрх зардалд шаардагдах хөрөнгийг аймгийн Засаг даргын нөөц сангийн шагнал урамшуулал, буцалтгүй тусламжийн зардлаас олгож зохион байгуулалтаар хангаж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч (А.Жаргалсайхан)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Д.АЮУРБУНЬ



۵۵/۴۴

۲۵ ۷۵ ۲۵۰
 بقسط بقسط بقسط

[illegible][illegible][illegible]